



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/616

Номгон

Ажилсаг төвийн үйл ажиллагаанд дэмжлэг
үзүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтын 32 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Үйлдвэрлэл, үйлчилгээний “Ажилсаг” төвийн түрээсийн төлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Түрээсийн хөнгөлөлтийн санхүүгийн дэмжлэгэд шаардлагатай 21.000.000 (Хорин нэгэн сая) төгрөгийг 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулж “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”-д шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Ажилсаг төвийн үйл ажиллагаа, санхүүжилтийг тухай бүр тайлагнаж ажиллахыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний гүйцэтгэх захирал (Н.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

842311633